

Х-1, Д-1, ХН-115, Нугалбар-2

Нийслэл хүрээний тэргүүн зэргийн газар нь: Их чөлөө ба нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар гудамжинд хандсан бас хүрээний баруун их чөлөөнөөс гуравдугаар хөндлөн гудамж хүртэлх газрууд. Жич их хүрээнээс урагш Сэлбэ гол хүртэл ба гандан хийдийн өмнө этгээдээс Сэлбэ гол урагш урссан өнцөг тохиолдох Төвөдийн хорооны хойд гудамж хүртэл зүүн зүг эрс чиглэхүйд оролцсон зээлийн хагас хувийн газрууд болмуй. Энэхүү тэргүүн зэрэг газрын өмнө хязгаар нь гаалийн хорооноос баруун зээлийн газар очих гудамжинд хандсан ба хорооны зүүн хойд этгээдийн хойш хандсан газрууд бас мөнхүү хороодын зүүн хойд тал нэгэн хэсэг хорооны зах дундаас зүүн этгээд вангийн хорооны баруун хойд талын нэгэн өнцөг хүртэл. Түүнээс их зам гудамжны өмнө этгээдийн хороодын орон сав нийтэд чиглэж, эмчийн хорооны зүүн этгээд болох өмнөөс хойш гарсан зам хүртэл болмуй. Хойд хязгаар нь хүрээний баруун өмнөөс Амбан ханы хорооны баруун өмнө этгээд болох гадаад яам бүхий хэсэг орон сав чиглүүлж түүнээс зүүн тийш олон яамны арын гудамжаар Сэлбэ голын баруун этгээдэд их замын гудамжны хойд этгээдэд буй гурван хэсэг орон савыг оролцуулан ялтны гяндан ба эмчийн хорооны хойд этгээд бээр болмуй.

Майма хотын тэргүүн зэргийн газар нь: Хэрмэнд бүхий газрууд баруун захын дунд хаалганаас мөн хотын баруун зах суварга хүртэл замын хоёр этгээдийн нүүр газар болмуй.

Нийслэл хүрээний хоёрдугаар зэрэг газруудын өмнө өмнө этгээд нь гандан хийдийн баруун өмнө этгээдээс эхлэн урагш хандсан ирмэгээр зүүн тийш Оросын тусгай газрыг хүртэл баруун хязгаар нь гандангийн баруун өмнө этгээдээс хойд зүг эрс чиглэмүй. Хойд хязгаар нь: Гандан ба баруун дамнуурчин, хүрээний хойд захаар зүүн хойд өнцөгт хүрээд түүнээс зэвсгийн хашааны хойд талын нэгэн хэсэг хашааны баруун хойд өнцгийг чиглүүлээд, мөн түүний араар зүүн өмнө хүрээнээс консулынд очих зам Оросын тусгаар газрын уулзар хүртэл болмуй. Аймаг хотын хоёрдугаар зэргийн газрын өмнө этгээд энэхүү урьд дурдсан ирмэг захаар зүүн тийш Улиастайн гол хүртэл нь Улайстайн голыг дагаж төмөр утсыг хүрээд баруун хойш мөн төмөр утсаар замнан Улиастайн голоос салбарлаж усыг хүртэл хойд ба баруун этгээдийн хязгаар нь мөн ус дагах болмуй.

Хоёрдугаар зэргийн газрын захын орон саваас цааш арван газрын дотор бүхий газрууд цөм гуравдугаар зэргийн газрууд болмуй.